



ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2018 оны 02 дугаар сарын 03

№ 01/67 ДУА-2018/9/1 СТА-ТШЗ Мандалговь хот

Зөрчил арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.1-д тодорхойлсон бүрэн эрхийн хүрээнд Дундговь аймаг дахь Төрийн аудитын газрын 2018 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу Сайнцагаан сумын 3-р сургуулийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар 312,534.00 /гурван зуун арван хоёр мянга таван зуун гучин дөрвөн/ төгрөгийн дараах зөрчил илэрлээ.

1. Ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэлийн 30,000.00 төгрөгийг урамшууллын зардлаас зарцуулсан.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16.5.5-д /батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах/, Сангийн сайдын 2014 оны 55 тоот тушаалаар батлагдсан “Эдийн засгийн ангилал”-ын /Урамшуулал-Төрийн албаны тухай хууль болон бусад хууль тогтоомжийн дагуу ажлын үр дүнг үнэлэн олгох урамшууллын зардлыг энэ ангилалд бүртгэнэ./,

2. Албан хаагчдын цалинг шатлал ахиулан, 282,534.00 төгрөгийг олгосон.





Энэ нь УИХ-ын 2017 оны 04 дүгээр сарын 14-ний өдрийн 29 дүгээр тогтоолын 4-т /төрийн албан хаагчдын цалин хөлсийг 2017-2018 онд одоогийн түвшинд хэвээр хадгалах буюу царцаах .../, 5-д /төрийн албан хаагчдын албан тушаалын зэрэглэл, цалингийн шатлал ахиулахыг 2017-2019 онд түр зогсоож, энэ талаар шийдвэр гаргахгүй байхыг бүх шатны төсвийн захирагч нарт даалгах/, Төсвийн тухай хуулийн 6.4.1-д /төсвийг үр ашигтай хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах/ гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Төрийн аудитын тухай хуулийн 15.1.12-т /Аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх, хууль тогтоомж, эрх зүйн хэм хэмжээ тогтоосон бусад шийдвэрийг боловсронгуй болгох саналыг холбогдох байгууллагад тавих/, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2014 оны 138 дугаар тушаалаар батлагдсан Төрийн аудитын байгууллагын ажилтны нийтлэг эрх, үүргийн тухай дүрмийн 2.2.3-т /Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийг хэрэгжүүлэх хүрээнд төрийн аудитын байгууллагын ахлах аудитор, ахлах шинжсээч, аудитор, шинжсээч нь аудитын явцад илэрсэн төлбөрийг барагдуулах, зөрчлийг арилгуулах зорилгоор төлбөрийн акт, албан шаардлага өгөх/, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2016 оны 09 дүгээр сарын 09-ны өдрийн А/95 дугаар тушаалаар баталсан Төлбөрийн акт тавих, албан шаардлага өгөхөд баримтлах журмын 4.1.3-д /Төсвийн хөрөнгийг үр ашиггүй, зориулалт бусаар, батлагдсан хэмжээнээс хэтрүүлэн зарцуулж, Төсвийн тухай хуулийн холбогдох зүйл заалтыг зөрчсөн/, 4.1.5-д /Байгуулсан гэрээ, хэлцэл мөрдөж байгаа хууль тогтоомж, дүрэм журмын шаардлага, нөхцлийг хангаагүй/ заасныг тус тус үндэслэн ШААРДАХ НЬ:

1. Зардлыг зориулалтын дагуу зарцуулах;
2. Батлагдсан төсвийн хөрөнгийг холбогдох хууль, журмын дагуу зарцуулах, төсвийн хэмнэлтийн горимд шилжин ажиллах;

3. Албан шаардлагыг хэрэгжүүлж, биелэлтийг аймгийн Төрийн аудитын газарт 2018 оны 03 дугаар сарын 25-ны дотор албан ёсоор ирүүлэхийг Сайнцагаан сумын 3-р сургуулийн захирал О.Оюунханд, нягтлан бодогч Н.Бээжинсүрэн нарт хариуцуулав.

### АЛБАН ШААРДЛАГЫГ

<b>ӨГСӨН<sup>1</sup>:</b>	<b>ЗӨВШӨӨРСӨН:</b>
АУДИТОР 	
Т.ОЮУН-ЭРДЭНЭ	ЗАХИРАЛ 
НЯГТЛАН БОДОГЧ 	О.ОЮУНХАНД
	Н.БЭЭЖИНСҮРЭН

117146211  
31040003 0001075

<sup>1</sup> Акт, албан шаардлагын биелэлт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.2-д "Төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтныг үүрэгт ажлаас нь халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ" гэж заасны дагуу хариуцагч албан тушаалтанд хариуцлага тооцуулахаар эрх бүхий албан тушаалтанд санал хүргүүлнэ.